*Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын*
*даргын 2023 оны 98 дугаар тушаалын*
*6 дугаар хавсралт*

# ГАЗРЫН ТОСНЫ БОДЛОГЫН ХЭРЭГЖИЛТИЙГ ЗОХИЦУУЛАХ ГАЗРЫН АХЛАХ ШИНЖЭЭЧ БАТСУУРЬ ОВОГТОЙ БАТ-ОРГИЛЫН 2025 ОНЫ хагас жилийн ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

**Нэг. Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт**

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Гүйцэтгэлийн түвшин | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин (биелэлт) | Эхэлсэн, дууссан хугацаа | Биелэлтийн хувь |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| **Зорилт 2. Газрын тосны бүтээгдэхүүний 3-6 сарын хэрэглээний нөөц бүрдүүлэхэд шаардлагатай улсын нөөцийн шатахууны агуулахын барилга байгууламжийг ашиглалтад оруулна.** | | | | | | | |
| **ШСБ-3.3, ЗГҮАХ-3.2.8. Дотоодын түүхий эдэд тулгуурласан газрын тос боловсруулах үйлдвэрийг барьж байгуулна.** | | | | | | | |
| 1. | Арга хэмжээ 6.2.1 Газрын тосны бүтээгдэхүүний хангамжийн тогтвортой байдлыг хангах ажлыг зохион байгуулах | Газрын тосны бүтээгдэхүүн, сая тн. | 2024 онд импортолсон газрын тосны бүтээгдэхүүний хэмжээ 2.5 сая тонн | 1.0 сая тн. | 2025 оны 05 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар нийт 1,14 сая тонн газрын тосны бүтээгдэхүүн импортолсноос бүх төрлийн шатахуун 1,06 сая тонн байна. | 2025.01.01-2025.06.10 | 100 |
| 2. | Арга хэмжээ 7.2.2 Экологийн өндөр ангилал бүхий Евро-5 стандартын шатахууны хэрэглээг нэмэгдүүлэх ажлыг зохион байгуулах. | Евро-5 стандартын шатахууны хэрэглээ, тонноор | 201,342 тн | 114,094 тн | 2025 оны 05 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар нийт 1,14 сая тонн газрын тосны бүтээгдэхүүн импортолсноос бүх төрлийн шатахуун 1,06 сая тонн байна. Үүнээс К5 /Евро-5/ ангилалын шатахуун 184,3 мян тонн буюу нийт шатахууны 17 хувийг эзэлж байна. | 2025.01.01-2025.06.10 | 100 |
| 3. | Арга хэмжээ 8.2.3 Төр, хувийн хэвшлийн түншлэл, улсын төсвийн | Улсын нөөцийн шатахууны | 2024 оны байдлаар Ажлын хэсэг | | Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн | 2025.01.01-2025.06.10 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | хөрөнгөөр улсын нөөцийн шатахууны агуулахыг барьж байгуулна | агуулахыг барьж байгуулна. Хувиар | байгуулж тооцоо, судалгаа зураг төслийн санхүүжилтийг ЭЗХЯ-ны төсөвт суулгасан. | | 3.3.1.9-д “Газрын тосны бүтээгдэхүүний 3-6 сарын хэрэглээний нөөц бүрдүүлэхэд шаардлагатай улсын нөөцийн шатахууны агуулахын барилга байгууламжийг ашиглалтад оруулна” гэж тусгагдсан. Тус зорилтын хэрэгжилтийг хангах хүрээнд шатахууны улсын нөөц бүрдүүлэх, хадгалахад шаардлагатай агуулахын барилга байгууламжийг барих, ашиглалтад оруулах төслийн бэлтгэл ажлыг хангах, холбогдох эрх зүйн орчин бүрдүүлэх үйл ажиллагааг зохион байгуулах, хэрэгжүүлэх төслийн нэгж байгуулах шаардлага тулгарч Засгийн газрын тогтоолын төсөл бэлтгэж, яамдын бүх сайд нараас санал авч нэгтгэн товёлж Засгийн газраар хэлэлцүүлэн 2025 оны 03 дугаар сарын 19-ний өдрийн 146 дугаар тогтоолоор батлуулсан байна. | | |
| 4. | Арга хэмжээ 9.2.4 Газрын тосны бүтээгдэхүүний компанийн нөөцийг бүрдүүлэх ажлыг зохион байгуулах. | Компанийн 30 хоногийн нөөцийн хэмжээ, мян.тн. | 132.7 мян.тонн | 146.5 мян.тонн | Газрын тосны бүтээгдэхүүний компанийн нөөц 2025 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн байдлаар бүх шатахуун 146,015 тонн байна. Үүнээс Аи-92 автобензин 44,099 тонн, дизелийн түлш 60,783 тонны тус тус нөөцтэй байна | 2025.01.01-2025.06.10 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 5. | Арга хэмжээ 10.2.5 Бүх төрлийн шатахуун импортлох, бөөний болон жижиглэнгийн худалдаа эрхлэх тусгай зөвшөөрлийг олгох, сунгах, түдгэлзүүлэх, хүчингүй болгох талаар санал боловсруулж, шийдвэрлүүлэх ажлыг бодлогын удирдамжаар хангах | Газрын тосны бүтээгдэхүүний тухай хууль, Зөвшөөрлийн тухай хуулийн хүрээнд тусгай зөвшөөрлийг олгох, сунгах, түдгэлзүүлэх, хүчингүй болгох асуудлыг шийдвэрлүүлсэн байна. | 2024 онд бөөний 71, импортлох 58, жижиглэнгийн худалдаа эрхлэх 75 | бөөний 8, импортлох 5, жижиглэнгийн худалдаа эрхлэх 10 | 2025 оны эхний хагасд: бөөний 22, импортлох 15, жижиглэнгийн худалдаа эрхлэх 21 | 2025.01.01-2025.06.10 | |
| **Зорилт 3. Газрын тосны салбарын стандарт, дүрэм, журмын хэрэгжилтийг хангах, ажлыг зохион байгуулах, хяналт тавина.** | | | | | | | |
| 1. | Арга хэмжээ 11.3.1 "Газрын тосны бүтээгдэхүүний чанарын стандарт, хяналтын тогтолцоог сайжруулж, хангамжийг тогтворжуулах" ажлын хүрээнд эрх зүйн баримт бичиг, дүрэм журам, норм, стандартын төсөлд санал боловсруулах, газрын тосны бүтээгдэхүүний чанар, стандартад хяналт тавих ажлыг холбогдох байгууллагуудтай хамтран зохион байгуулах | Гүйцэтгэсэн ажлын тоо | 1 | 0 | АҮЭБ-ийн Сайдын 2025 оны А/18 дугаар тушаалаар байгуулагдсан ажлн хэсэгт орж ажиллаж байна. Тус ажлын хэсэг "Газрын тосны бүтээгдэхүүний тухай" хуулийн нэмэлт өөрчлөлт оруулах төсөл бэлтгэх үүрэгтэй. | 2025.01.01-2025.06.10 | 100 |
| 2. | Арга хэмжээ 12.3.2 Газрын тосны салбарын судалгаа, мэдээ, мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлэх | Мэдээллийн сан үүсгэж хэрэглэгчийг | Салбарын мэдээ, мэдээллийн цахим сан | Салбарын мэдээ, мэдээллийн цахим сан | Газрын тосны бүтээгдэхүүний бөөний болон жижиглэнгийн үнэ, импорт, үлдэгдэл, гадаад зах зээлийн үнийн мэдээг 7 хоног бүр шинэчлэн гарган | 2025.01.01-2025.06.10 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | салбарын мэдээллээр хангах | бүрдүүлэх, хөгжүүлэх | бүрдүүлэх, хөгжүүлэх | нэгтгэж удирдлагад танилцуулсан. | | |
| 3. | Арга хэмжээ 13.3.3 Газрын тосны гадаад дотоод зах зээл, хөрөнгө оруулалттай холбоотой судалгаа, мэдээллийг нэгтгэх | Салбарын зах зээл, хөрөнгө оруулалттай холбоотой мэдээллийн сан үүсгэж хэрэглэгчийг салбарын мэдээллээр хангах | Салбарын зах зээл, хөрөнгө оруулалтын мэдээллийн цахим санг бий болгох, хөгжүүлэх | | Газрын тосны олон улсын бирж дээрх "Брент" болон "WTI" төрлийн газрын тосны үнийг 7 хоног бүр шинэчлэн гаргаж, дэлхийн газрын тосны зах зээлийн мэдээг тогтмол нэгтгэн удирдлагад танилцуулсан байна. | 2025.01.01-2025.06.10 | 100 |
| 4. | Арга хэмжээ 14.3.4 Газрын тосны бүтээгдэхүүний агуулах, шатахуун түгээх станцын үлдэгдэл нөөцийн мэдээг тогтмол авах ажлыг цахимжуулах асуудлыг зохион байгуулах | | Зохион байгуулсан эсэх. Тийм:1, Үгүй:0 | 0 | Газрын тосны бүтээгдэхүүний агуулах, шатахуун түгээх станцын үлдэгдэл, нөөцийн мэдээг цахим сайт болох (mpetro.smartsolution.mn)-ээр 7 хоногт 2 удаа ААН-үүдээс авч нэгтгэн удирдлагыг мэдээллээр ханган ажиллаж байна. | 2025.01.01-2025.06.10 | 100 |
| **Зорилго 2. Төрийн захиргааны болон хүний нөөцийн удирдлагын манлайллыг хангаж, эрх зүйн зөвлөгөө, салбарын гадаад хамтын ажиллагааг өргөжүүлэх, байгууллагын мэдээллийн технологийг хөгжүүлэх** | | | | | | | |
| 1. | Арга хэмжээ 17.4.3 Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийг нэгтгэн гаргаж, холбогдох нэгжид хүргүүлэх | - | Хуулийн хугацаанд 0-хэрэгжүүлээгүй<br>1-хэрэгжүүлсэн | 0 | Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Газрын тосны бодлогийн хэрэгжилтийг зохицуулах газрын хамрах хүрээнд 2025 оны 01 болон 02 дугаар улирлын Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийн биелэлтийг нэгтгэн Төрийн захиргааны удирдлагын газарт хүргүүлсэн. | 2025.01.01-2025.06.10 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 2. | Арга хэмжээ 19.4.5 Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөөний хэрэгжилтийг нэгтгэн гаргаж, холбогдох нэгжид хүргүүлэх | | Хуулийн хугацаанд 0-хэрэгжүүлээгүй<br>1-хэрэгжүүлсэн | 0 | Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Газрын тосны бодлогийн хэрэгжилтийг зохицуулах газрын хамрах хүрээнд 2025 оны 01 болон 02 дугаар улирлын Улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрийн хэрэгжилтийг нэгтгэн гаргаж Төрийн захиргааны удирдлагын газарт хүргүүлсэн | 2025.01.01-2025.06.10 | 100 |
| 3. | Арга хэмжээ 25.4.10 Иргэн, аж ахуйн нэгж, байгууллагаас яаманд ирүүлсэн санал, хүсэлт, өргөдөл, гомдлыг судалж, шийдвэрлүүлэх, хариуг хүргүүлэх арга хэмжээ авах | | Хугацаанд нь шийдвэрлэсэн эсэх<br>0-үгүй<br>1-тийм | 0 | 2025 оны 05 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар иргэн, аж ахуйн нэгж, байгууллагаас албан бичгээр ирүүлсэн нийт бичиг-102, явуулсан бичиг-34 санал, хүсэлт, өргөдөл, гомдлыг 2-ыг хүлээн авч, хариу бичгийн төслийг боловсруулан удирдлагад танилцуулж, хариуг хуулийн хугацаанд хүргүүлэн ажилласан. | 2025.01.01-2025.06.10 | 100 |
| 4. | Арга хэмжээ 26.4.11 Албан хэрэг хөтлөлтийн стандарт, зааврын хэрэгжилтийг хангуулж хяналт тавьж ажиллах | | Холбогдох журмын дагуу хэрэгжилтийг хангуулсан эсэх 0-үгүй, 1-тийм | 0 | Албан хэрэг хөтлөлтийн стандарт, зааврын дагуу хэрэгжилтийг хангаж ажиллаж байна. | 2025.01.01-2025.06.10 | 100 |

**Нэмэлт үүрэг даалгавар (арга хэмжээ)-ын биелэлт**

| Д/д | Үүрэг даалгавар (арга хэмжээ) | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин (биелэлт) | Эхэлсэн, дууссан хугацаа | Биелэлтийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1. | | | | | | 2025.01.01-2025.06.10 | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 2. | | | | | | 2025.01.01-2025.06.10 | |

**Хоёр. Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт**

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Гүйцэтгэлийн түвшин | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин (биелэлт) | Эхэлсэн, дууссан хугацаа | Биелэлт ийн хувь |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| 1. | Арга хэмжээ 2.1 Байгууллагын зүгээс болон бусад төрийн ба төрийн бус байгууллагуудаас зохион байгуулах салбарын чиглэлийн сургалтад хамрагдах | Сургалтад хамрагдсан байна. | Цахим сургалтад хамрагдаж, салбарын талаарх мэдлэг, мэдээллээ баяжуулсан байна. | 1 | Байгууллагын зүгээс болон бусад төрийн ба төрийн бус байгууллагуудаас зохион байгуулах салбарын чиглэлийн сургалтад хамрагдсан | 2025.01.01-2025.06.10 | 100 |

**ТАЙЛАН ГАРГАСАН:**

Аналах шинжээч ................ Бат-Оргил ................ / ................ Бат-Оргил ................ 2025.06.10

( Албан тушаал ) ( Нэр, гарын үсэг ) ( Огноо )

*Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын*
*даргын 2023 оны 98 дугаар тушаалын*
*6 дугаар хавсралт*

# ГАЗРЫН ТОСНЫ БОДЛОГЫН ХЭРЭГЖИЛТИЙГ ЗОХИЦУУЛАХ ГАЗРЫН АХЛАХ ШИНЖЭЭЧ ПҮРЭВДОРЖИЙН ХҮРЭЛХҮҮГИЙН 2025 ОНЫ ХАГАС ЖИЛИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

**Нэг. Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт**

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Гүйцэтгэлийн түвшин | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин (биелэлт) | Эхэлсэн, дууссан хугацаа | Биелэлтийн хувь |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| **Зорилт 1. Газрын тосны ордын ашиглалт, олборлолтын хэмжээг 2024 онд 626000 тоннд хүргэнэ.** | | | | | | | |
| **ШСБ-3.3, ЗГҮАХ-3.2.8. Дотоодын түүхий эдэд тулгуурласан газрын тос боловсруулах үйлдвэрийг барьж байгуулна.** | | | | | | | |
| 1. | Арга хэмжээ 1.1<br>Газрын тос, уламжлалт бус газрын тосны эрэл, хайгуул, ашиглалтыг эрчимжүүлж нөөцийг өсгөх. | Хөрөнгө оруулалт болон олборлолтын хэмжээ | 190.8 сая ам.доллар, 568,725 тонн | 10.0 сая ам.доллар | **Монгол Улсын хэмжээнд Газрын тосны Баталгаат нөөц:** Хайгуулын ажлын үр дүнгээр 2010, 2012, 2021 онуудад газрын тосны баталгаат нөөцийг **333.79 сая тонн** гэж бүртгэсэн.<br>**Ашиглалтын баталгаат нөөц: 43.40 сая тонн**-оор нөөцийн нэгдсэн санд бүртгэн авсан.<br>Монгол Улсын хэмжээнд **43.40 сая тонн** ашиглалтын баталгаат нөөцөөс 1996-2023 оны хооронд **11.1 сая тонн** газрын тос олборлосон ба үлдэгдэл ашиглалтын баталгаат нөөц **32.0 сая тонн** байна. | 2025,01,01-2025,06,10 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | Монгол Улсын хэмжээнд 2025 оны байдлаар газрын тосны хайгуулын 10 Бүтээгдэхүүн хуваах гэрээ /БХГ/, ашиглалтын шатанд 4 БХГ, нүүрсний давхаргын метан хийн хайгуулын 8 БХГ хэрэгжиж байна. Газрын тосны хайгуулын нээлттэй 15 талбай байна.<br><br>2025 оны эхний хагас жилийн байдлаар хайгуулын үе шатны ажилд 13,3 сая ам.долларын хөрөнгө оруулалт хийгдээд байна. | | |
| 2. | Арга хэмжээ 1.2.<br>Газрын тосны хайгуулын талбайд шинээр газрын тосны орд нээж, нөөц тогтоох ажлыг зохион байгуулна. | ЭБМЗ-ийн газрын тосны салбар хуралдааны тоо | 4 талбайд олборлолтын үйл ажиллагаа явуулж байна. | Нөөц нэмэгдсэн байна. | Засгийн газрын 2009 оны 05 дугаар сарын 20-ны өдрийн 147 дугаар тогтоолоор газрын тосны хайгуулын Галба XI талбайд Зон хэн юу тиан ХХК-тай байгуулсан Бүтээгдэхүүн хуваах гэрээ (БХГ)-г баталсан. Газрын тосны хайгуулын тусгай зөвшөөрлийг 2009 оны 07 дугаар сарын 23-ны өдөр авсан.<br>Зон хэн юу тиан ХХК нь 2009-2019 онд Галба XI талбайн Өлгий хотгорт нийт 1316 тууш км 2 хэмжээст чичирхийллийн судалгаа, 358 км² талбайд 3 хэмжээст чичирхийллийн судалгаа хийж, хайгуул, үнэлгээний 14 цооног | 2025,01,01-2025,06,10 | 90 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | өрөмдөж, нийт 20628 тууш метр өрөмдлөг хийсэн. 8 цооногоос авсан чөмөг чулуун дээжинд лабораторийн шинжилгээ хийж, 6 цооногт туршилт, үнэлгээ хийсэн. БХГ-т Галба XI талбайн Өлгийн ордын газрын тосны баялгийн үнэлгээ, нөөцийн тооцооны тайланг Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн Газрын тосны салбар хуралдаанаар 2024 оны 01 дүгээр сарын 26-ны өдөр хэлэлцүүлж, зохиогчийн хувилбараар нөөцийг хүлээн авах шийдвэр гаргасан<br>Үүнд Баталгаат зэрэглэл (1P)-ээр байрандаа анх байгаа газрын тос (OOIP)-ны эзлэхүүн нь 12.5 сая баррель буюу 1.8 сая тонн, үүнээс ашиглах хэмжээ буюу ашиглалтын баталгаат нөөц нь 1.1 сая баррель буюу 160.4 мянган тонн, Магадлалтай зэрэглэл (2P)-ээр байрандаа анх байгаа газрын тос (OOIP)-ны эзлэхүүн нь 16.5 сая баррель буюу 2.4 сая тонн, үүнээс ашиглах хэмжээ буюу баталгаат нэмэх нь магадлалтай нөөц (P1+P2) нь 2.1 сая баррель буюу 295.2 мянган тонн, Боломжтой зэрэглэл (3P)-ээр байрандаа анх байгаа газрын тос (OOIP)-ны эзлэхүүн нь 21.5 сая | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | баррель буюу 3.1 сая тонн, үүнээс ашиглах хэмжээ буюу баталгаат нэмэх нь магадлалтай нэмэх нь боломжтой нөөц нь (P1+P2+P3) нь 3.4 сая баррель буюу 490.4 мянган тонн болно. Тус компанитай газрын тос ашиглах талбайн хэмжээг Газрын тосны тухай хуулийн 9.1.6-д заасний дагуу тохиролцох асуудал ажлийн хэсгийн хүрээнд хэдэ хэдэн удаа хэлэлцээр хийсэн хэдий ч эцэслэн тохиролцож чадаагүй болно. | | |
| | Арга хэмжээ 1.3.<br>Газрын тосны ордын ашиглалт, олборлолтыг урт хугацаанд тогтвортой хадгалж, боломжит хэмжээгээр нэмэгдүүлэх ажлыг зохион байгуулж, дэмжлэг үзүүлэх. | Газрын тосны олборлолт, мян.тн. | 568,725 тонн | 200,000 тонн | Монгол Улсын хэмжээнд **43.40 сая тонн** ашиглалтын баталгаат нөөцөөс 1996-2024 оны хооронд **11.5 сая тонн** газрын тос олборлосон ба үлдэгдэл ашиглалтын баталгаат нөөц **32.0 сая тонн** байна.<br>2025 онд нийт 4 248 850 баррель буюу 579 000 тонн газрын тос олборлож экспортлохоос 2025 оны 06 дугээр сарын 04-ний өдрийн байдлаар Монгол Улсын хэмжээнд нийт 1 631 907 баррель буюу 221 494 тонн газрын тос олборлож, 1 504 671 баррель буюу 204 449 тонн газрын тосыг БНХАУ-д экспортлоод байна. Хагас | 2025,01,01-2025,06,10 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | жилийн төлөвлөгөөний биелэлт 100 хувь. | | |
| | Арга хэмжээ 1.4. Газрын тос хайх, ашиглах тусгай зөвшөөрлийг олгох, сунгах, түдгэлзүүлэх, хүчингүй болгох талаар санал боловсруулж, шийдвэрлүүлэх ажлыг бодлогын удирдамжаар хангах; | Холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн шийдвэрлүүлсэн байна. | 3 | 1 | Дорнод аймгийн Матад сумын Засаг даргын 2024 оны 05 дугаар сарын 27-ны өдрийн А/76 дугаар захирамжаар газар ашиглах зөвшөөрлийг олгосон, мөн дэлхий нийтийг хамарсан Ковид-19 цар тахлын улмаас газрын тос ашиглах үйл ажиллагааг гүйцэтгэх боломжгүй болсон зэрэг давагдашгүй хүчин зүйлийн нөлөө, нөхцөл байдлыг үндэслэн газрын тосны Матад-XX талбайд Бүтээгдэхүүн хуваах гэрээний дагуу газрын тостой холбогдсон үйл ажиллагаа явуулж буй “Петро Матад” ХХК-ийн газрын тос ашиглах тусгай зөвшөөрлийг 2024 оны 05 дугаар сарын 27-ны өдрөөс эхлэхээр шинэчлэн тогтоож, 2049 оны 05 дугаар сарын 27-ны өдрийг хүртэлх хугацаагаар олгох тухай АҮЭБСайдын 2025.06.04-ний өдрийн А/145 тоот тушаал гаргуулсан. Мөн 974 тоот тусгай зөвшөөрлийг “Петро Матад” ХХК-д олгоод байна. | 2025,01,01-2025,06,10 | 100 |
| **Зорилт 2. Төрийн захиргааны болон хүний нөөцийн удирдлагын манлайллыг хангаж, эрх зүйн зөвлөгөө, дэмжлэг үзүүлэх, иргэд хуулийн этгээдэд үзүүлж байгаа үйлчилгээг сайжруулна.** | | | | | | | |
| | Арга хэмжээ 2.1. Газар, хэлтсийн 2025 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг | | 0 | 1 | Газар, хэлтсийн 2025 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг | 2025,01,01-2025,06,10 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | нэгтгэн боловсруулж батлуулах, газрын 2025 оны төлөвлөгөөний биелэлтийг нэгтгэж гарган холбогдох нэгжид хүргүүлэх. | Хуулийн хугацаанд<br>0-хэрэгжүүлээгүй<br>1-хэрэгжүүлсэн | | | нэгтгэн боловсруулж ТЗУГ-т хүргүүлэн батлуулсан. | | |
| 3. | Арга хэмжээ 2.2. АҮЭБЯ-ны стратеги төлөвлөгөөний биелэлтийг нэгтгэж гарган холбогдох нэгжид хүргүүлэх | Хуулийн хугацаанд<br>0-хэрэгжүүлээгүй<br>1-хэрэгжүүлсэн | 0 | 1 | АҮЭБЯ-ны ГТБХЗГ-ын стратеги төлөвлөгөөний 2025 оны эхний хагас жилийн биелэлтийг нэгтгэж гарган холбогдох нэгжид хүргүүлсэн. | 2025,01,01-2025,06,10 | 100 |
| | Арга хэмжээ 2.3. Иргэн, аж ахуйн нэгж, байгууллагаас яаманд ирүүлсэн санал, хүсэлт, өргөдөл, гомдлыг судалж, шийдвэрлүүлэх, хариуг хүргүүлэх арга хэмжээ авах. | Өргөдөл гомдлын шийдвэрлэлтэнд хяналт тавих шийдвэрлэлтийн %<br>0-нэмэгдээгүй<br>1-нэмэгдсэн | 70% | 80% | 2025 оны 6 дугаар сарын 10-ний байдлаар 29 Иргэн, аж ахуйн нэгж, байгууллагаас хариуцах ажлын хүрээнд ирүүлсэн санал, хүсэлт, өргөдөл, гомдлыг судалж, холбогдох шийдвэр болон хариуг хүргүүлэн ажилласан. | 2025,01,01-2025,06,10 | 100 |
| | Арга хэмжээ 2.4. Албан хэрэг хөтлөлтийн стандарт, заавруудын хэрэгжилтийг хангуулж хяналт тавьж ажиллах. | Холбогдох журмын дагуу хэрэгжилтийг хангуулсан эсэх | Бичиг хэргийн шийдвэрлэлт 91 % | 92% | Албан хэрэг хөтлөлтийн стандарт, зааврууды дагуу хэрэгжилтийг хანган ажиллаж байна | 2025,01,01-2025,06,10 | 100 |

**Хоёр. Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт**

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Гүйцэтгэлийн түвшин |
|---|---|---|

| | | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин (биелэлт) | Эхэлсэн, дууссан хугацаа | Биелэлт ийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| 1. | Арга хэмжээ 1. Байгууллагын зүгээс болон бусад төрийн ба төрийн бус байгууллагуудаас зохион байгуулах салбарын чиглэлийн цахим сургалтад хамрагдах | Сургалтад хамрагдах | - | Сургалтанд хамрагдсан байна | ХХЕГ болон ОБЕГ-аас цэргийн албан хаагчтай холбоотой эрх зүйн шинэчлэлтэй холбоотой мөн гамшгийн үед авах арга хэмжээний талаар зохион байгуулсан сургалтад хамрагдсан. | 2025,01,01-2025,06,10 | 100 |

**ТАЙЛАН ГАРГАСАН:**

ГТБХЗГ-и ахлах шинжээч ..... П.Хүрэлхүү ..... 2025 .06. .10.

( Албан тушаал ) ( Нэр, гарын үсэг ) ( Огноо )

*Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын 2023 оны 98 дугаар тушаалын 6 дугаар хавсралт*

# ГАЗРЫН ТОСНЫ БОДЛОГЫН ХЭРЭГЖИЛТИЙГ ЗОХИЦУУЛАХ ГАЗРЫН ШИНЖЭЭЧ БАТЖАРГАЛЫН МАНЗУШИРЫН 2025 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

**Нэг. Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт**

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Гүйцэтгэлийн түвшин | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин (биелэлт) | Эхэлсэн, дууссан хугацаа | Биелэлтийн хувь |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| **Зорилт-1: Газрын тосны бүтээгдэхүүний 3-6 сарын хэрэглээний нөөц бүрдүүлэхэд шаардлагатай улсын нөөцийн шатахууны агуулахын барилга байгууламжийг ашиглалтад оруулна.** | | | | | | | |
| 1. | Арга хэмжээ 6.2.1 Газрын тосны бүтээгдэхүүний хангамжийн тогтвортой байдлыг хангах ажлыг зохион байгуулах. | Газрын тосны бүтээгдэхүүн, сая тн. | 2024 онд импортолсон газрын тосны бүтээгдэхүүний хэмжээ 2.5 сая тонн | 1.0 сая тн. | 2025 оны 05 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар нийт 1,14 сая тонн газрын тосны бүтээгдэхүүн импортолсноос бүх төрлийн шатахуун 1,06 сая тонн байна. | 2024.01.01 - 2024.06.10 | 100% |
| 2. | Арга хэмжээ 7.2.2 Экологийн өндөр ангилал бүхий Евро-5 стандартын шатахууны хэрэглээг нэмэгдүүлэх ажлыг зохион байгуулах. | Евро-5 стандартын шатахууны хэрэглээ, тонноор | 201,342 тн | 114,094 тн | 2025 оны 05 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар нийт 1,14 сая тонн газрын тосны бүтээгдэхүүн импортолсноос бүх төрлийн шатахуун 1,06 сая тонн байна. Үүнээс К5 /Евро-5/ ангилалын шатахуун 184,3 мян тонн буюу нийт шатахууны 17 хувийг эзэлж байна. | 2024.01.01 - 2024.06.10 | 100% |
| 3. | Арга хэмжээ 9.2.4 Газрын тосны бүтээгдэхүүний компанийн нөөцийг бүрдүүлэх ажлыг зохион байгуулах. | Компанийн 30 хоногийн нөөцийн хэмжээ, мян.тн. | 132.700 тонн | 179,880 тн | Газрын тосны бүтээгдэхүүний компанийн нөөц 2025 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн байдлаар бүх шатахуун 146,015 тонн байна. Үүнээс Аи-92 автобензин 44,099 тонн, дизелийн түлш 60,783 тонны тус тус нөөцтэй байна. | 2024.01.01 - 2024.06.10 | 100% |

| Зорилт-2: Газрын тосны салбарын стандарт, дүрэм, журмын хэрэгжилтийг хангах, ажлыг зохион байгуулах, хяналт тавих; | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 4. | Арга хэмжээ 12.3.2 Газрын тосны салбарын судалгаа, мэдээ, мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлэх | Мэдээллийн сан үүсгэж хэрэглэгчийг салбарын мэдээллээр хангах | Салбарын мэдээ, мэдээллийн цахим сан бүрдүүлэх, хөгжүүлэх | Салбарын мэдээ, мэдээллийн цахим сан бүрдүүлэх, хөгжүүлэх | - Газрын тосны бүтээгдэхүүний бөөний болон жижиглэнгийн үнэ, импорт, үлдэгдэл, гадаад зах зээлийн үнийн мэдээг 7 хоног бүр шинэчлэн гарган нэгтгэж удирдлагад танилцуулсан. | 2024.01.01 - 2024.06.10 | 100% |
| 5. | Арга хэмжээ 13.3.3 Газрын тосны гадаад дотоод зах зээл, хөрөнгө оруулалттай холбоотой судалгаа, мэдээллийг нэгтгэх | Салбарын зах зээл, хөрөнгө оруулалттай холбоотой мэдээллийн сан үүсгэж хэрэглэгчийг салбарын мэдээллээр хангах | Салбарын зах зээл, хөрөнгө оруулалтын мэдээллийн цахим санг бий болгох, хөгжүүлэх | Салбарын зах зээл, хөрөнгө оруулалтын мэдээллийн цахим санг бий болгох, хөгжүүлэх | -Газрын тосны олон улсын бирж дээрх “Брент” болон “WTI” төрлийн газрын тосны үнийг 7 хоног бүр шинэчлэн гаргаж, дэлхийн газрын тосны зах зээлийн мэдээг тогтмол нэгтгэн удирдлагад танилцуулсан байна.<br>Газрын тосны бүтээгдэхүүний жижиглэнгийн худалдаа эрхлэгч зарим аж ахуйн нэгж, байгууллагууд Аи-92 автобензиний жижиглэнгийн үнийг 2025 оны 05 дугаар сарын 23-ны өдөр Улаанбаатар хотод литр тутамд 2590 төгрөг болгож 200 төгрөгөөр нэмэгдүүлсэн байна. Эдгээр ААН-үүдийн гаргасан үйлдэл нь Монгол Улсын Өрсөлдөөний тухай хуулийн 7.1.2-т заасан “Давамгай байдлаа хууль бусаар ашиглаж бараа бүтээгдэхүүнд үндэслэлгүйгээр хэт өндөр үнэ тогтоох” гэсэн заалтыг болон бусад хууль, тогтоомжийг зөрчсөн эсэхийг шалгаж өгч, хамтран ажиллахыг хүссэн албан бичгийг 2025 оны 05 дугаар сарын 26-ны өдрийн 02/1599 дугаар тоотоор хүргүүлсэн. | | |
| 6. | Арга хэмжээ 14.3.4 Газрын тосны бүтээгдэхүүний агуулах, шатахуун түгээх станцын үлдэгдэл нөөцийн мэдээг тогтмол | Зохион байгуулсан эсэх. Тийм:1, Үгүй:0 | Зохион байгуулсан эсэх. Тийм:1, Үгүй:0 | 0 | Газрын тосны бүтээгдэхүүний агуулах, шатахуун түгээх станцын үлдэгдэл, нөөцийн мэдээг цахим сайт болох (mpetro.smartsolution.mn)-ээр 7 хоногт 2 удаа ААН-үүдээс авч нэгтгэн удирдлагыг мэдээллээр хангаж ажиллаж байна. | 2024.01.01 - 2024.06.10 | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | авах ажлыг цахимжуулах асуудлыг зохион байгуулах | | | | | | |
| **Зорилт 3. Төрийн захиргааны болон хүний нөөцийн удирдлагын манлайллыг хангаж, эрх зүйн зөвлөгөө, дэмжлэг үзүүлэх, салбарын гадаад хамтын ажиллагааг өргөжүүлж, санхүү, эдийн засаг, хөрөнгө оруулалтыг төлөвлөн зохицуулж иргэд хуулийн этгээдэд үзүүлж байгаа үйлчилгээний дундаж хугацаа** | | | | | | | |
| 7. | Арга хэмжээ 17.4.2 Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийг нэгтгэж гарган холбогдох нэгжид хүргүүлэх | Хуулийн хугацаанд 0-хэрэгжүүлээгүй, 1-хэрэгжүүлсэн | 0 | 1 | - Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Газрын тосны бодлогийн хэрэгжилтийг зохицуулах газрын хамрах хүрээнд 2025 оны 01 болон 02 дугаар улирлын Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийн биелэлтийг нэгтгэн Төрийн захиргааны удирдлагын газарт хүргүүлсэн. | 2024.01.01 - 2024.06.10 | 100% |
| 8. | Арга хэмжээ 21.4.6 Улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрийн хэрэгжилтийг нэгтгэж гарган холбогдох нэгжид хүргүүлэх | Хуулийн хугацаанд 0-хэрэгжүүлээгүй, 1-хэрэгжүүлсэн | 0 | 1 | - Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Газрын тосны бодлогийн хэрэгжилтийг зохицуулах газрын хамрах хүрээнд 2025 оны 01 болон 02 дугаар улирлын Улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрийн хэрэгжилтийг нэгтгэн гаргаж Төрийн захиргааны удирдлагын газарт хүргүүлсэн. | 2024.01.01 - 2024.06.10 | 100% |
| 9. | Арга хэмжээ 25.4.10 Иргэн, аж ахуйн нэгж, байгууллагаас яаманд ирүүлсэн санал, хүсэлт, өргөдөл, гомдлыг судалж, шийдвэрлүүлэх, хариуг хүргүүлэх арга хэмжээ авах | Өргөдөл гомдлын шийдвэрлэлтэнд хяналт тавих шийдвэрлэлтийн %, 0-нэмэгдээгүй,1-нэмэгдсэн | 70% | 70% | 2025 оны 05 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар иргэн, аж ахуйн нэгж, байгууллагаас албан бичгээр ирүүлсэн нийт 34 үүнээс ирсэн бичиг-19, явуулсан бичиг-15 санал, хүсэлт, өргөдөл, гомдлыг хүлээн авч, хариу бичгийн төслийг боловсруулан удирдлагад танилцуулж, хариуг хуулийн хугацаанд хүргүүлэн ажилласан. | 2024.01.01 - 2024.06.10 | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 10. | Арга хэмжээ 26.4.11 Албан хэрэг хөтлөлтийн стандарт, заавруудын хэрэгжилтийг хангуулж хяналт тавьж ажиллах | Холбогдох журмын дагуу хэрэгжилтийг хангуулсан эсэх | Бичиг хэргийн шийдвэрлэлт 91 % | Албан хэрэг хөтлөлтийн стандарт хангаж ажилласан байна. | Албан хэрэг хөтлөлтийн стандарт, заавруудын дагуу хэрэгжилтийг хангаж ажиллаж байна. | 2024.01.01 - 2024.06.10 | 100% |

**Нэмэлт үүрэг даалгавар (арга хэмжээ)-ын биелэлт**

| Д/д | Үүрэг даалгавар (арга хэмжээ) | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин (биелэлт) | Эхэлсэн, дууссан хугацаа | Биелэлтийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1. | 1. Газрын тосны бүтээгдэхүүний хангамж, нийлүүлэлт, ОХУ-аас Монгол улс руу шатахууны төмөр замын тээвэрлэлтийг шуурхай явуулах, шатахууны хангамжийн тогтвортой байдлыг хангах талаар шийдвэрлүүлэх | Тайлагнасан эсэх: 0-Үгүй 1-Тийм | - | 1 | “Эрчис ойл” ТӨХХК-аас 2025 оны 01 дүгээр сарын 30-ний өдрийн 01/57 дугаар тоот албан бичгээр ирүүлсэн хүсэлтийн дагуу ОХУ-ын “РН-Аэро ХХН” –тай төлбөр тооцоо гүйцэтгэхэд тулгарч буй асуудалтай холбоотой дэмжлэг хүссэн бичгийг Голомт банк болон Худалдаа хөгжлийн банканд 2025 оны 02 дугаар сарын 04-ний өдрийн 01/344 дугаар албан бичгээр хүргүүлсэн. Монгол-Оросын хувь нийлүүлсэн нийгэмлэг Улаанбаатар төмөр зам нь 2025 оны 02 дугаар сард тодорхойгүй шалтгаанаар ОХУ-аас импортоор орж ирэх “Дашваанжил групп” ХХК-ийн 45 вагонцистерн, “Гор газ" ХХК-ийн 14 вагонцистерн, “Юни газ" ХХК-ийн 14 вагонцистерн, нийт 73 вагонцистерн шингэрүүлсэн шатдаг хийг төмөр замаар хүлээн авах зөвшөөрөл олгохгүй буцаасан асуудлаар импортлогч аж ахуйн нэгжүүдээс манай яаманд хандаад байна. Дээрх асуудлыг судлан шийдвэрлэж, ОХУ-аас шингэрүүлсэн шатдаг хий /LPG/-г төмөр замаар хүлээн авахтай холбоотой үйл ажиллагааг хэвийн явуулахад дэмжлэг үзүүлж, хамтран ажиллах тухай ЗАМ, ТЭЭВРИЙН ЯАМНЫ ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГА С.БАТБОЛД-д 2025 оны 02 | 2024.01.01 - 2024.06.10 | 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | дугаар сарын 20-ны өдрийн 02/575 дугаар албан бичгээр хүргүүлсэн.<br>- Монгол-Оросын хувь нийлүүлсэн нийгэмлэг “Улаанбаатар төмөр зам”-аас 2025 оны 02 дугаар сарын 25-ны өдрийн 03/657 дугаартай албан бичгээр Газрын тосны бүтээгдэхүүн импортлогч ААН-үүд вагонцистерний буулгалтыг зохион байгуулахгүй, өртөөдийн зам дээр ачаалал үүсгэн, Толгойт, Аршаант, Улаанбаатар өртөөд болон замын өртөөнүүдийг эзлэн төмөр замын аюулгүйн бүсэд удаан хугацаагаар зогсож, УБТЗ-ын тээвэр, зохион байгуулалтын ажилд хүндрэл учруулж байгаа асуудлаар манайд хандаад байгаа тул нэр бүхий 13 ААН-д тусгай зөвшөөрөл цуцлах хүртэлх холбогдох арга хэмжээ авч ажиллах талаар 2025 оны 03 дугаар сарын 10-ны өдрийн 02/717 дугаар албан бичгээр мэдэгдэл хүргүүлсэн. | | |
| 2. | Газрын тосны бүтээгдэхүүний хангамж, үнийг тогтворжуулах ажлыг зохион байгуулах, хяналт тавих үүрэг бүхий төр, хувийн хэвшил, иргэний нийгмийн хамтарсан Зөвлөлийн бүрэлдэхүүнийг шинэчлэн батлах | Тайлагнасан эсэх:<br>0-Үгүй<br>1-Тийм | - | 1 | “Газрын тосны бүтээгдэхүүний хангамж, үнийг тогтворжуулах ажлыг зохион байгуулах, хяналт тавих үүрэг бүхий төр, хувийн хэвшил, иргэний нийгмийн хамтарсан Зөвлөлийн бүрэлдэхүүнийг шинэчлэн батлах тухай” тогтоолын төсөл болон яамдаас ирүүлсэн төслийн саналын товъёог нэгтгэж тус тогтоолын төслийг Засгийн газраар хэлэлцүүлэн 2025 оны 03 дугаар сарын 19-ний өдрийн 140 дугаар тогтоолоор шинэчлэн батлуулсан байна. | 2024.01.01<br>-<br>2024.06.10 | 100% |
| 3. | Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 3.3.1.9-д “Газрын тосны бүтээгдэхүүний 3-6 сарын хэрэглээний нөөц бүрдүүлэхэд | Тайлагнасан эсэх:<br>0-Үгүй<br>1-Тийм | - | 1 | Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 3.3.1.9-д “Газрын тосны бүтээгдэхүүний 3-6 сарын хэрэглээний нөөц бүрдүүлэхэд шаардлагатай улсын нөөцийн шатахууны агуулахын барилга байгууламжийг ашиглалтад оруулна” гэж тусгагдсан. Тус зорилтын хэрэгжилтийг хангах хүрээнд | 2024.01.01<br>-<br>2024.06.10 | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | шаардлагатай улсын нөөцийн шатахууны агуулахын барилга байгууламжийг ашиглалтад оруулах төслийн бэлтгэл ажлыг хангах, холбогдох эрх зүйн орчин бүрдүүлэх үйл ажиллагааг зохион байгуулах, хэрэгжүүлэх төслийн нэгж байгуулах | | | | шатахууны улсын нөөц бүрдүүлэх, хадгалахад шаардлагатай агуулахын барилга байгууламжийг барих, ашиглалтад оруулах төслийн бэлтгэл ажлыг хангах, холбогдох эрх зүйн орчин бүрдүүлэх үйл ажиллагааг зохион байгуулах, хэрэгжүүлэх төслийн нэгж байгуулах шаардлага тулгарч Засгийн газрын тогтоолын төсөл бэлтгэж, яамдын бүх сайд нараас санал авч нэгтгэн товёлж Засгийн газраар хэлэлцүүлэн 2025 оны 03 дугаар сарын 19-ний өдрийн 146 дугаар тогтоолоор батлуулсан байна. | | |

**Хоёр. Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт**

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Гүйцэтгэлийн түвшин | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин (биелэлт) | Эхэлсэн, дууссан хугацаа | Биелэлтийн хувь |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| 1. | Арга хэмжээ 2.1 Байгууллагын зүгээс болон бусад төрийн ба төрийн бус байгууллагуудаас зохион байгуулах салбарын чиглэлийн сургалтад хамрагдах | Сургалтад хамрагдах | - | 1 | - Монгол Улсын Засгийн газрын худалдан авах ажиллагааны А3 сертификат олгох сургалтад 2025 оны 02 дугаар сарын 24, 25-ны өдрүүдэд суралцаж амжилттай шалгалт өгч тэнцсэн байна. -Удирдлагын академийн Ахлах түшмэлийн мэргэшүүлэх багц сургалтад 2025 оны 05 дугаар сарын 20-ны өдрөөс суралцаж эхэлсэн байна. | 2024.01.01-2024.06.10 | 100% |
| | | Сертификат авсан байна | - | 1 | - Удирдлагын академийн Төрийн албан хаагчийн дунд хугацааны сургалтад 3 сарын хугацаанд хамрагдаж 2025 оны 02 дугаар сарын 19-ний өдрийн а/82 тоот тушаал сертификатаар төгсөв. | 2024.01.01-2024.06.10 | 100% |

**ТАЙЛАН ГАРГАСАН:**

ГТБХЗГ-ын шинжээч Б.МАНЗУШИР / ......................... / 2025.06.12

*( Албан тушаал )* *( Нэр, гарын үсэг )* *( Огноо )*

*Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын*
*даргын 2023 оны 98 дугаар тушаалын*
*6 дугаар хавсралт*

## АЖ ҮЙЛДВЭР, ЭРДЭС БАЯЛГИЙН ЯАМНЫ ГАЗРЫН ТОСНЫ БОДЛОГЫН ХЭРЭГЖИЛТИЙГ ЗОХИЦУУЛАХ ГАЗРЫН АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН БААТАРЫН ЛХАМСҮРЭНГИЙН 2025 ОНЫ ХАГАС ЖИЛИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

**Нэг. Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт:**

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Гүйцэтгэлийн түвшин | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин (биелэлт) | Эхэлсэн, дууссан хугацаа | Биелэлт -ийн хувь |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| **Зорилт 1.1. “ШСБ-3.3, ЗГҮАХ-3.2.8. Дотоодын түүхий эдэд тулгуурласан газрын тос боловсруулах үйлдвэрийг барьж байгуулна”-ыг хэрэгжүүлсэн арга хэмжээний биелэлт** | | | | | | | |
| 1. | Арга хэмжээ 1.1 Газрын тос, уламжлалт бус газрын тосны эрэл, хайгуул, ашиглалтыг эрчимжүүлж, нөөцийг өсгөх хүрээнд холбогдох ажлыг тухай бүр зохион байгуулах | Хөрөнгө оруулалтын хэмжээ | 190.8 сая ам.доллар | Үүнээс хайгуулын ажилд эхний хагас жил 13 сая, жилийн эцэст 26 сая ам.доллар | Газрын тос, уламжлалт бус газрын тосны эрэл, хайгуулын ажлыг эрчимжүүлэх хүрээнд АМГТГ-ын даргын 2025 оны А/01 дүгээр тушаалаар байгуулсан ажлын хэсэгт гишүүнээр ажиллаж, 2025 оны эхний улирлад багтаан газрын тос, уламжлалт бус газрын тосны хайгуулын БХГ бүхий аж ахуйн нэгжүүдийн 2025 оны хөтөлбөр, төсвийг аж ахуйн нэгж тус бүрээр батлуулсан. Үүний дагуу эдгээр ААН-үүдээс хайгуулын салбарт оны эхнээс өссөн дүнгээр нийт 13,361,426 ам.долларын хөрөнгө оруулалт хийгдсэн бөгөөд гүйцэтгэл 2025 оны эхний хагас жилийн байдлаар зорилтод түвшинд хүрсэн байна. | 2025.01.01-2025.06.15 | 100 хувь |
| 2. | Арга хэмжээ 1.2. Газрын тосны хайгуулын талбайнуудад шинээр Бүтээгдэхүүн хуваах гэрээ байгуулж, хайгуулын ажлын | Шинээр байгуулсан БХГ-ний тоо | 3 | 2 | Засгийн газрын 166, 167 дугаар тогтоолоор эрх олгосны дагуу газрын тосны хайгуулын Борзон VII талбайд 2025.01.16-ны өдөр “Петро Матад Энержи Лимитед” ХХК, уламжлалт бус газрын тосны хайгуулын Ачит XXXVII талбайд 2025.01.06-ны өдөр | 2025.01.01-2025.06.15 | 100 хувь |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх | | | | "Тэмүүжин металс" ХХК тус тус БХГ байгуулах ажлыг АМГТГ-тай хамтран зохион байгуулсан. 2025 онд нийт 2 БХГ шинээр байгуулж, эхний хагас жилийн зорилтод түвшинд хүрсэн. Хайгуулын ажлын хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх хүрээнд 2025 онд хайгуулын салбарт нийт 26 сая ам.долларын хөрөнгө оруулалт хийхээр төлөвлөсөн бөгөөд өмнөх оны мөн үеийн бодит гүйцэтгэлтэй харьцуулахад хөрөнгө оруулалтын хэмжээ 6 сая орчим ам.доллароор нэмэгдэж, 21 хувиар өссөн үзүүлэлттэй байна. | | |
| 3. | Арга хэмжээ 1.3. Газрын тосны хайгуулын талбайд шинээр газрын тосны орд нээж, нөөц тогтоох ажлыг зохион байгуулах | ЭБМЗ-ийн газрын тосны салбар хуралдааны тоо | 0 | 0 | Өнөөгийн байдлаар газрын тосны хайгуулын 10, уламжлалт бус газрын тосны хайгуулын 8 талбайд нийт 16 гэрээлэгч ААН хайгуул судалгааны ажил үргэлжлүүлэн гүйцэтгэж байна. Эдгээрээс бусад газрын тосны хайгуулын талбайнуудын талаар олон нийтэд сурталчлах, холбогдох ажлуудыг зохион байгуулах чиглэлийг АҮЭБ-ийн сайдын 2025.02.26-ны өдрийн 01/661 дүгээр албан бичгээр АМГТГ-т хүргүүлсэн. Уламжлалт бус газрын тосны хайгуулын талаар мэдээлэл хүссэн УИХ-ын гишүүн Д.Ганмаагийн асуулгад дэлгэрэнгүй танилцуулга, мэдээлэл боловсруулж, АҮЭБ-ийн сайдын 2025.04.23-ны өдрийн 01/1224 дүгээр албан бичгээр хүргүүлсэн. Үүнээс гадна газрын тосны хайгуулын үйл ажиллагаатай холбоотой тус газарт ирүүлсэн нийт 29 санал, хүсэлтэд тухай бүр хариу боловсруулж, хүргүүлсэн. 2025 онд Төхөм X урд талбайд хайгуулын 2, Эргэл XII талбайд 1, Гурвантэс XXXV талбайд туршилт, олборлолтын 3 цооног, Богд IV талбайд 2 цооногт 1300 тууш.м өрөмдлөг, цооногийн геофизикийн судалгаа 1300 тууш.м, Онги V талбайд цооногийн туршилт | 2025.01.01-2025.06.15 | 70 хувь |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | 1 цооногт, цооногийн геофизикийн судалгаа 1300 тууш.м, Тавантолгой XXXIII талбайд 1 цооногт 1633.1 тууш.м туршилтын хэвтээ цооногийн өрөмдлөг, Номгон IX талбайд 1 цооногт 1000 тууш.м туршилт үнэлгээний өрөмдлөгийн ажил тус тус хийгдэхээр тогтсон. Хайгуулын компаниудын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх зорилгоор хүсэлт гаргасан нийт 7 талбайг хэсэгчлэн буцаах тухай асуудлыг Сайдын зөвлөлийн хуралдаанаар хэлэлцүүлэх бэлтгэлийг бүрэн хангасан. | | |
| **Зорилт 2. "Салбарын хууль, эрхзүйн орчныг боловсронгуй болгож, давхардал хийдлийг арилгах, хяналт тавихтай холбоотой харилцааг боловсронгуй болгоно"-ыг хэрэгжүүлсэн арга хэмжээний биелэлт** | | | | | | | |
| 1. | Арга хэмжээ 2.1. Газрын тосны салбарын дүрэм, журам, заавар, норм норматив, стандарт, аргачлал, маягтыг боловсруулах, нэмэлт өөрчлөлт оруулах ажлыг холбогдох газартай хамтран зохион байгуулах | Гүйцэтгэсэн эсэх Тийм:1, Үгүй 0 | 0 | 1 | Зөвшөөрлийн тухай хуульд нийцүүлэн хүчингүй болгохоор эрх бүхий байгууллагаас урьдчилсан байдлаар шийдвэрлэсэн "Гэрээлэгчийг сонгон шалгаруулах журам"-ын холбогдох зүйл, заалт, хэсгийг Газрын тосны тухай хуульд нэмэлт, өөрчлөлтөөр оруулах тухай хуулийн төсөл боловсруулж, 2025.04.10-ны өдөр ТЗУГ-ын Хуулийн хэлтэст, 2025.05.11-ний өдөр ЗГХЭГ, ЭЗХЯ-ны хамтарсан ажлын хэсэгт тус тус хүргүүлсэн. Хуулийн төсөл Зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон бусад хуулийн төслийн хамт УИХ-ын ээлжит хуралдаанаар хэлэлцэгдэхэд бэлэн болсон. (ЗГХЭГ 2025.05.13, ХЭГ/1370 тоот) | 2025.01.01-2025.06.15 | 100 хувь |
| **Зорилт 3. "Газрын тосны салбарын стандарт, дүрэм, журмын хэрэгжилтийг хангах ажлыг зохион байгуулах, хяналт тавина"-ыг хэрэгжүүлсэн арга хэмжээний биелэлт** | | | | | | | |
| 1 | Арга хэмжээ 3.1. Газрын тосны гадаад дотоод зах зээл, хөрөнгө оруулалттай холбоотой судалгаа, мэдээллийг тухай бүр нэгтгэх | Хэрэглэгчдийг салбарын мэдээллээр хангасан эсэх Тийм:1, Үгүй:0 | 0 | 1 | Газрын тосны хайгуул, ашиглалтын талаарх танилцуулга болон метан хийн хайгуулын талбайнуудын талаарх мэдээллийг тогтмол шинэчлэн боловсруулж, удирдлагад танилцуулсан. Газрын тосны олборлолт, экспорт болон улсын төсөвт төвлөрүүлж буй газрын тосны | 2025.01.01-2025.06.15 | 100 хувь |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | орлогын мэдээ, дэлхийн зах зээл дээрх газрын тосны үнийн мэдээлэл зэрэг өдөр тутам болон долоо хоногийн тутмын мэдээллийг АМГТГ-аас хүлээн авч нэгтгэн, мэдээллийн сан үүсгэж, тогтмол баяжуулж байна. Метан хий болон хийн түлшний зах зээлийн судалгаа, холбогдох мэдээллийг шинэчлэн Ерөнхий сайдын 2025.02.25-ны өдрийн шуурхай хуралдаанд танилцуулах илтгэлд нэгтгүүлсэн. Мөн нүүрсний давхаргын метан хийн хайгуул, судалгаа, хийн түлшний хэрэглээний талаар илтгэл, танилцуулга бэлтгэж, БНСУ-ын К-Петро байгууллагаас зохион байгуулсан “Газрын тосны бүтээгдэхүүн, нүүрсний шинжилгээний мэргэжилтэнд зориулсан сургалт”-д хэлэлцүүлж, оролцсон. Газрын тосны хайгуулын салбарын өнөөгийн байдлын талаар эрдэм шинжилгээний өгүүлэл бэлтгэж, ШУТИС-ийн “Газрын тос-2025” №25 (11) дугаарт нийтлүүлсэн. | | |
| **Зорилт 4. “Аж үйлдвэр, эрдэс баялгийн салбарын тусгай зөвшөөрөл олгох, сунгах эсэх асуудлыг ил тод, хөнгөн шуурхай шийдвэрлэнэ”-ийг хэрэгжүүлсэн арга хэмжээний биелэлт** | | | | | | | |
| 1 | Газрын тос хайх тусгай зөвшөөрлийг олгох, сунгах асуудлыг цахим системээр дамжуулан шийдвэрлэх | Цахим системд шийдвэрлэсэн хүсэлтийн тоо | 0 | 1 | Тусгай зөвшөөрлийн www.license.mn цахим системээр дамжуулан хүсэлт ирүүлсэн “Монголиа Фойсон Энержи” ХХК-д газрын тосны хайгуулын Хэрлэн тохой-XXVIII талбайд газрын тос хайх тусгай зөвшөөрөл олгох тухай АУЭБ-ийн сайдын 2025.04.03-ны өдрийн А/74 дүгээр тушаалыг батлуулж, зөвшөөрлийн цахим гэрчилгээ олгох ажлыг хамтран зохион байгуулсан. | 2025.01.01-2025.06.15 | 100 хувь |
| **Зорилт 5. “Төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулна”-ыг хэрэгжүүлсэн арга хэмжээний биелэлт** | | | | | | | |
| 1 | Арга хэмжээ 1. Нэгжийн долоо хоног тутмын үйл ажиллагааны тайланг нэгтгэж, холбогдох газарт хүргүүлэх | Хугацаанд тайлагнасан эсэх Тийм:1, Үгүй:0 | 0 | 1 | Газрын үйл ажиллагааны 7 хоног тутмын тайланг тухай бүр нэгтгэн гаргаж, холбогдох нэгжид хугацаанд нь хүргүүлсэн. | 2025.01.01 2025.06.15 | 100 хувь |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 2 | Арга хэмжээ 2. 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн Үндсэн чиглэлийн хэрэгжилтийг нэгтгэн гаргаж, холбогдох нэгжид хүргүүлэх | Хугацаанд тайлагнасан эсэх Тийм:1, Үгүй:0 | 0 | 1 | Тухай бүр нэгтгэн гаргаж, холбогдох нэгжид хугацаанд нь цахимаар хүргүүлсэн. | 2025.01.01 2025.06.15 | 100 хувь |
| 3 | Арга хэмжээ 2. Иргэн, аж ахуйн нэгж, байгууллагаас яаманд ирүүлсэн санал, хүсэлт, өргөдөл, гомдлыг судалж, шийдвэрлүүлэх, хариуг шуурхай хүргүүлэх | Хугацаанд шийдвэрлэ-сэн эсэх Тийм:1, Үгүй:0 | 0 | 1 | Тайлант хугацаанд аж ахуйн нэгж, байгууллагаас албан бичгээр ирүүлсэн нийт 46 хүсэлт хүлээн авч, 19 албан бичгээр хариу хүргүүлж, 2 тусгай зөвшөөрлийн санал хүсэлтийг хүлээн авч хугацаанд нь шийдвэрлүүлсэн. Хугацаа хэтэрсэн шийдвэрлэлт байхгүй. | 2025.01.01 2025.06.15 | 100 хувь |
| 4 | Арга хэмжээ 3. Цаг үеийн шаардлагаар удирдлагаас өгсөн болон бусад үүрэг даалгаврыг хэрэгжүүлж, тайлагнах | Хугацаанд шийдвэрлэ-сэн эсэх Тийм:1, Үгүй:0 | 0 | 1 | Удирдлагаас өгсөн үүрэг даалгаврыг тухай бүр хэрэгжүүлж, хугацаанд нь тайлагнасан. Тухайлбал шинэчлэн баталж буй “Газрыг улсын тусгай хэрэгцээнд авах, гаргах, түүний хэмжээ заагийг тогтоох, ашиглах журам”-д санал боловсруулж, холбогдох нэгжид хүргүүлсэн. Талбайн хэмжээ, хил зааг, солбицлыг АМГТГ-ын даргын А/163 дугаар тушаалаар батлан тус яаманд ирүүлсний дагуу нүүрсний давхаргын метан хийн хайгуулын Борзон VII талбайд нээлттэй сонгон шалгаруулалт зарлах тухай Сайдын тушаалын төсөл бэлтгэн удирдлагуудад танилцуулсан. Газрын тосны хайгуулын Арбулаг XXIX талбайд БХГ байгуулсан “Макс ойл” ХХК-иас ирүүлсэн хүсэлтэд хариу боловсруулж, газрын даргын 2025.03.13-ны өдрийн 07/761 дүгээр албан бичгээр хүргүүлсэн. Үндэсний аудитын газрын Нөхөн сэргээлттэй холбоотой хяналт, шалгалтын хүрээнд газрын тос, уламжлалт бус газрын тосны хайгуулын чиглэлээр үйл ажиллагаа эрхэлж буй гэрээлэгч компаниудын холбогдох мэдээллийг 2020-2024 оны байдлаар нэгтгэн гаргаж, ХШҮДАГ-т | 2025.01.01 2025.06.15 | 100 хувь |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | 2025.05.01-ний өдөр хүргүүлсэн. Газрын тосны хайгуулын Төхөм X урд талбайд хайгуулын ажил гүйцэтгэж буй Монголын алт (МАК) ХХК-ийн БХГ-ний эрх үүрэг шилжүүлэх тухай асуудлыг холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн судалж, Засгийн газрын тогтоолын төсөл, танилцуулгыг бэлтгэн АҮЭБ-ийн сайдын 2025.05.09-ний өдрийн 01/1460 дугаар албан бичгээр санал авахаар яамдад хүргүүлсэн. | | |
| **Нэмэлт үүрэг даалгавар (арга хэмжээ)-ын биелэлт:** | | | | | | | |
| 1 | Үүрэг даалгавар (арга хэмжээ) 1. “Газрын тосны салбарт 2022-2024 онд хэрэгжүүлэх хамтын хэлэлцээр”-ийн хэрэгжилтийг дүгнэх ажлыг зохион байгуулах | Гүйцэтгэлийн хувь | 0 | 100 хувь | ТНБД-ын 2025 оны А/03 дугаар тушаалаар байгуулагдсан “Газрын тосны салбарт 2022-2024 онд хэрэгжүүлэх хамтын хэлэлцээр”-ийг дүгнэх үүрэг бүхий ажлын хэсгийн Нарийн бичгийн даргаар ажиллаж, газрын тосны салбарын Үйлдвэрчний эвлэлүүдийн холбооны нийт гишүүн байгууллагуудын оролцоогоор тус хэлэлцээрийг заалт тус бүрээр дүгнэх ажлыг 2025.03.28-ны өдөр амжилттай зохион байгуулсан. Хэлэлцээрийн хэрэгжилтийг талууд 99.7 хувийн гүйцэтгэлтэйгээр дүгнэсэн бөгөөд нэгдсэн дүгнэлтийг холбогдох байгууллагуудаар баталгаажуулж, Монголын Тээвэр холбоо, газрын тосны үйдвэрчний эвлэлүүдийн холбоонд 2025.03.31-ний өдөр хүргүүлсэн. | 2025.01.01-2025.06.15 | 100 хувь |
| 2 | Үүрэг даалгавар (арга хэмжээ) 2. Газрын тостой холбогдсон үйл ажиллагаа эрхэлж буй гэрээлэгч ААН-үүдийн шүүхийн маргаантай холбоотой асуудалд итгэмжлэлийн дагуу хариуцагчаар оролцож, ажиллах | Гүйцэтгэлийн хувь | 0 | 100 хувь | ТНБД-ын 2025.01.24-ний өдрийн 02/222 дугаар албан бичгээр өгсөн итгэмжлэлийн дагуу газрын тосны хайгуулын Сулинхээр XXIII талбайд БХГ байгуулсан “Шунхлай энержи” ХХК-ийн нэхэмжлэлтэй Арбитрын хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны хуралдаанд 2025.01.28, 2025.03.19, 2025.04.16-ны өдрүүдэд Хуулийн хэлтэстэй хамтран оролцож, нэмэлт мэдээлэл болон | 2025.01.01-2025.06.15 | 100 хувь |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | нотлох баримтыг хүргүүлсэн. Мөн өртөг нөхөгдөх зардал болон хайгуулын хугацаатай холбоотойгоор холбогдох шатны шүүхэд маргаан үргэлжилж буй “Метан газ ресурс” ХХК, “Жи Өү Эйч” ХХК-иудын хүсэлтэд тухай хариу боловсруулж хүргүүлсэн. | | |

**Хоёр. Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт:**

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Гүйцэтгэлийн түвшин | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин (биелэлт) | Эхэлсэн, дууссан хугацаа | Биелэлт ийн хувь |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| 1. | Арга хэмжээ 1. Газрын тосны хадгалалт, тээвэрлэлт чиглэлээр ШУТИС-ийн Геологи, уул уурхайн сургуульд докторантурт суралцах | Суралцсан эсэх | 3-р курс | Төгсөх шат | ШУТИС-ийн Геологи уул уурхайн сургуульд Газрын тосны хадгалалт, тээвэрлэлтийн инженер мэргэжлээр докторантурт төгсөх жилдээ сурлагын голч дүн 3.96 дүнтэй суралцаж төгссөн. | 2025.01.01<br>2025.06.15 | 100 хувь |
| 2. | Арга хэмжээ 2. Төрийн албаны тухай хууль шинэчлэн батлагдсантай холбогдуулан төрийн албан хаагчийг мэргэшүүлэх багц сургалтад хамрагдах | Суралцсан эсэх | 0 | 1 | Ахлах түшмэлийн мэргэшүүлэх багц сургатад хамрагдаж, №А4165 тоот сертификат авсан. Мөн АМГТГ, БНСУ-ын Хийн аюулгүй байдлын корпорацитай хамтран зохион байгуулсан “Gas Safety 2025” сургалт, “Газрын тосны бүтээгдэхүүн, нүүрсний шинжилгээний мэргэжилтэнд зориулсан сургалт”-д тус тус хамрагдаж, сертификат авсан. | 2025.01.01<br>2025.06.15 | 100 хувь |

**ТАЙЛАН ГАРГАСАН:**
Газрын тосны бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын Ахлах мэргэжилтэн
*( Албан тушаал )*

.............................. / Б.Лхамсүрэн /
*( Нэр, гарын үсэг )*

2025.06.05
*( Огноо )*